

**1993, 2002, 2012, 2021 ОНЫ ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИУДАД ЗААСАН
ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ ТҮҮХЧИЛСЭН СУДАЛГАА**

2022.04.19

Улаанбаатар хот

1992 онд шинэ Үндсэн хуулиа тунхаглаж, баталсантай холбоотойгоор шүүхийн тухай хуулийг 1993 онд баталсан. Үүнээс хойш 3 удаа буюу 2002, 2012, 2021 онуудад шинэчлэн баталжээ.

1. Шүүгчийн туслах**1.1. Тавигдах шаардлага**

1993, 2002, 2012, 2021 оны хуулиудад шүүгчийн туслахад тавигдах шаардлагыг хуульчилсан байх бөгөөд бүх хуулиудад хууль зүйн дээд боловсрол буюу эрх зүйч мэргэжилтэй болон Монгол Улсын иргэн байх шаардлагыг тавьж иржээ. Харин 2002 оны хуулиас эхлэн дээрх 2 шаардлагаас гадна нэмэлт шаардлагуудыг тавьж эхэлсэн байна.

№	1993 он	2002 он	2012 он	2021 он
1	Хууль зүйн дээд боловсролтой	Хууль зүйн дээд боловсролтой	Эрх зүйч мэргэжилтэй	Эрх зүйч мэргэжилтэй
2	-	-	-	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй
3	Монгол Улсын иргэн байх	Монгол Улсын иргэн байх	Монгол Улсын иргэн байх	Монгол Улсын иргэн байх
4	-	Ял шийтгэлгүй байх	Ял шийтгэлгүй байх	Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй
5	-	-	Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байх	Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байх
6	-	-	Энэ хуульд заасан ёс зүйн шаардлагыг хангасан байх	Хуульд заасан ёс зүйн шаардлагыг хангасан байх
7	-	-	Тухайн ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, боловсрол, туршлагатай байх	Тухайн ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, боловсрол, туршлагатай байх

1.2. Чиг үүрэг

1993 оны шүүхийн тухай хуульд 2002, 2012, 2021 оны хуулиудаас ялгаатайгаар туслах шүүгч, туслах шүүгчийн бүрэн эрх гэсэн нэр томъёог ашигласнаас гадна туслах шүүгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг нэг бүрчлэн заасан байна. Харин 2002 оны шүүхийн тухай хуулиас эхлэн шүүгчийн туслах, туслахын хэрэгжүүлэх чиг үүрэг гэсэн томъёоллыг ашигласан байх бөгөөд хэрэгжүүлэх чиг үүргийг ерөнхийд нь зааж иржээ.

Иймд шүүхийн тухай хуулиудад заасан шүүгчийн туслахын чиг үүргийг харьцуулан харах боломжтой байдлаар 2002, 2012, 2021 оны хуулиудыг нэг хүснэгтэд, 1993 оны хуулийг тусад нь авч үзлээ.

№	1993 оны Шүүхийн тухай хуульд заасан туслах шүүгчийн бүрэн эрх ¹
1	ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйл.Нэхэмжлэлийг хүлээн авах
2	ИХШХШТХ-ийн 63 дугаар зүйл.Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах
3	ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйл.Хэрэг үүсгэх
4	ИХШХШТХ-ийн 66 дугаар зүйл.Хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа
5	ИХШХШТХ-ийн 67 дугаар зүйл.Зохигчид эвлэрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч шаардлагыг зөвшөөрөх, биелүүлэх
6	ИХШХШТХ-ийн 68 дугаар зүйл.Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх ба тусгаарлах
7	ИХШХШТХ-ийн 69 дугаар зүйл.Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах
8	ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйл.Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах
9	ИХШХШТХ-ийн 74 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
10	ИХШХШТХ-ийн 75 дугаар зүйл /шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаа/-ийн 75.1 хэрэг хянан шийдвэрлэхэд нотлох баримт хангалттай гэж зохигчид үзсэн, эсхүл энэ хуулийн 71 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүгч уг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг товлох 75.2 хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэх
11	ИХШХШТХ-ийн 79 дугаар зүйл.Хэрэг шилжүүлэх
12	ИХШХШТХ-ийн 126 дугаар зүйл.шийдвэр биелүүлэхийг хойшлуулах буюу хэсэгчлэн биелүүлэх, биелүүлэх арга журмыг өөрчлөх
13	ИХШХШТХ-ийн 134 дүгээр зүйл /гэрлэлт цуцлах тухай хэргийг шийдвэрлэх/-ийн 134.1 шүүх хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх болон шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх явцад гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна. 134.2 гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэр бүлийн байнгын хүчирхийлэлд байгаа тохиолдолд эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.
14	ИХШХШТХ-ийн 141 дүгээр зүйл.Хүнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгчийн ажиллагаа
15	ИХШХШТХ-ийн 145 дугаар зүйл /Хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэргийг хэлэлцэх/-ийн 145.1 хүсэлт хүлээн авсан шүүх нь шүүх-сэтгэц гэм судлалын шинжээч томилон, шинжилгээ хийлгэж, тухайн хүний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулна. 145.2 шинжилгээ хийлгэхээс зайлсхийсэн этгээдэд шүүгчийн захирамжийн дагуу албадан шинжилгээ хийлгэж болно.
16	ИХШХШТХ-ийн 157 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцуулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгчийн ажиллагаа
17	ИХШХШТХ-ийн 197, 200, 219, 225.2, 226.2, 228, 229 дүгээр зүйлийг 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүйд тооцсон.
18	ЭБШТХ-ийн 219 дүгээр зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх
19	ЭБШТХ-ийн 222 дугаар зүйл/яллагдагчийг шүүхэд шилжүүлэхэд шийдвэрлэвэл зохих асуудал/-ийн 222.1 яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэх, 222.2 шүүх хуралдааныг хаана, хэзээ хийх, 222.3 мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч аваагүй шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах,

¹ Туслах шүүгч нь бүрэн эрхийн хүрээнд процессын хуульд заасан ажиллагааг шүүгчийн даалгавраар гүйцэтгэнэ.

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

	222.4 шүүх хуралдаанд яллагдагч, өмгөөлөгч, гэрч, шинжээч, хохирогч, түүний өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, хэлмэрчийг дуудах, оролцуулах, 222.7 иргэний нэхэмжлэл болон хөрөнгө хураах ялыг хангах арга хэмжээ авах
20	ЭБШТХ-ийн 223 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үед гаргасан хүсэлтийг хянаж хэлэлцэх
21	ЭБШТХ-ийн 229 дүгээр зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж
22	ЭБШТХ-ийн 230 дугаар зүйл.хэргийг түдгэлзүүлэх, харьяаллын дагуу шүүхэд шилжүүлэх
23	ЭБШТХ-ийн 231 дүгээр зүйл.хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах
24	ЭБШТХ-ийн 233 дугаар зүйл.хэргийн материалтай танилцуулах
25	ЭБШТХ-ийн 234 дүгээр зүйл.яллах дүгнэлтийн хуулбарыг гардуулан өгөх
26	ЭБШТХ-ийн 350 дугаар зүйл. Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол болон магадлал, тогтоолыг биелүүлэх журам
27	ЭБШТХ-ийн 351 дүгээр зүйл.шийтгэгдсэн этгээдийг төрөл садны нь хүмүүстэй уулзуулах ба тэдэнд таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх болсныг мэдэгдэх
28	Захиргааны зөрчилтэй хэргийн нотлох баримтын бүрдлийг хангуулах
29	Хууль тогтоомж, шүүхийн шийдвэрийг сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохиох
30	Хуульд заасан бусад бүрэн эрх

№	2002	2012 ²	2021
1	Хэрэг, маргааны талаар судалгаа хийж танилцуулах	Шүүхэд ирүүлсэн тодорхой хэрэг, маргааны талаарх бичиг баримтын бүрдлийг судалж, шүүгчид танилцуулах	Шүүхэд ирүүлсэн тодорхой хэрэг, маргааны талаарх баримт бичгийн бүрдлийг судалж, шүүгчид танилцуулах
2	Техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх	Шүүгчийн үйл ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх	Шүүгчийн үйл ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх
3	-	Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх	Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх
4	-	Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн талаар болон бусад мэдээлэл бэлтгэх зэргээр шүүгчид туслах	Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн талаар болон бусад мэдээлэл бэлтгэх зэргээр шүүгчид туслах
5	-	Хавтаст хэргийг хөтлөх	Хэргийг товьёглон хөтлөх
6	-	Тодорхой хэрэг, маргааны талаарх мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Тодорхой хэрэг, маргааны талаарх мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах
7	-	Шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангахад оролцох	Шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангахад оролцох
8	-	Шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулах	Шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулах

² Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт “Шүүх нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий шүүхийн ажилтантай байх бөгөөд шүүхийн ажилтны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно” гэж заасны дагуу шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хэрэгжүүлэх чиг үүргийг Шүүхийн захиргааны хуульд заасан байна.

9	-	Тэмдэгтийн хураамж төлөгдсөн эсэхийг хянах	Улсын тэмдэгтийн хураамж төлөгдсөн эсэхийг хянах
10	Хуульд заасан бусад	Хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан бусад чиг үүрэг	Хуульд заасан бусад

Дээрх хүснэгтээс харахад 2002 оны хуульд шүүгчийн туслахын хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэг, маргааны талаар судалгаа хийж, танилцуулах, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхээр заасан бол 2012, 2021 оны хуулиудад хэрэгжүүлэх чиг үүргийг нэмэгдүүлсэн байх бөгөөд 2012 оны хуульд "... ажлын байрны тодорхойлолтод заасан бусад чиг үүрэг" гэж зааснаас бусад нь 2021 оны хуультай адилхан байна.

2. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

2.1. Тавигдах шаардлага

1993 оны хуульд шүүх хуралдааны нарийн бичгийн даргад тавигдах шаардлагыг хуульчлаагүй байна. Харин 2002 оноос эхлэн тавигдах шаардлагыг хуульчилсан байх бөгөөд зөвхөн 2002 онд л шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хууль зүйн дээд боловсролтой байх шаардлагыг тавьжээ.

№	1993 он	2002 он	2012 он	2021 он
1	-	Хууль зүйн дээд боловсролтой	-	-
2	-	Монгол Улсын иргэн байх	Монгол Улсын иргэн байх	Монгол Улсын иргэн байх
3	-	Ял шийтгэлгүй байх	Ял шийтгэлгүй байх	Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй
4	-	-	Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байх	Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байх
5	-	-	Энэ хуульд заасан ёс зүйн шаардлагыг хангасан байх	Хуульд заасан ёс зүйн шаардлагыг хангасан байх
6	-	-	Тухайн ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, боловсрол, туршлагатай байх	Тухайн ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, боловсрол, туршлагатай байх

2.2. Чиг үүрэг

1993, 2012, 2021 оны хуулиудад шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хэрэгжүүлэх чиг үүргийг хуульчилсан бол 2002 оны хуульд шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хэрэгжүүлэх чиг үүргийн хуульчлаагүй байна.

Иймд 1993, 2012, 2021 оны хуулиудад заасан шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хэрэгжүүлэх чиг үүргийг харьцуулан харах боломжтой байдлаар нэг хүснэгтэд орууллаа.

№	1993 он	2012 он	2021 он
1	Шүүх хуралдааны зохион байгуулалтын бэлтгэл хангах	Шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах	Шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах
2	Тэмдэглэл хөтлөх	Шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх	Шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

3	-	Шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах	Шүүх хуралдааныг дууны, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулах
4	-	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчид хуульд заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэргийн материалд хавсаргах	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчид хуульд заасны дагуу танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэрэгт хавсаргах
5	Хуульд заасан болон шүүгчээс хүлээлгэсэн үүрэг	Ерөнхий зөвлөлөөс баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан бусад чиг үүрэг	-

Дээрх хүснэгтээс харахад 1993 оны хуульд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны бэлтгэл хангах, тэмдэглэл хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан бол 2012, 2021 оны хуулиудад шүүх хуралдааныг дууны, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулах болон шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчид хуульд заасны дагуу танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэрэгт хавсаргах чиг үүргийг нэмэгдүүлж хуульчилсан байна. Харин 1993, 2012 оны хуулиудад заасан хуульд заасан болон шүүгчээс хүлээлгэсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтод заасан бусад чиг үүрэг 2021 оны шинэчилсэн хуульд тусгагдаагүй байна.

